



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТБ

Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг VI хороо, Эрх чөлөөний талбай,
Дипломат 95 цогцолбор, Утас: 324627, 324764, факс: 315326
E-mail: hnaran@globeinter.org.mn, globenews@globeinter.org.mn

2010 оны 9 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 98/10

Улаанбаатар
хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга хурандаа М.Ганхүү Танаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын ажилтнууд “Нийгмийн толь” өдөр тутмын сонины бүх нууцтай холбоотой баримт материал, нууц эх сурвалжийн жагсаалт агуулсан толгой компьютерийг хураан авсныг “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага эсэргүүцэж байна.

“Нийгмийн толь” сонины толгой компьютерийн оронд өөр компьютер, эд хөрөнгө санал болгосон боловч хүлээн аваагүй, хэдэн жил ашигласан энэ хуучин компьютер нь шүүхээс тогтоосон 1 сая 698 мянган төгрөгийн торгуулийг төлөхөд хүрэлцэхгүй, толгой компьютерийг битүүмжлэн лацдах боломж олгоогүй, түүнд байгаа мэдээллээ хуулж авах редакцийн хүсэлтэд татгалзаж буй зэргээс үүдэн энэ үйлдэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар хуульд заасан эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж, редакцийн үйл ажиллагаанд зориуд халдсан зорилготой арга хэмжээ гэж бид үзэж байна.

“Нийгмийн толь” сонин 2009 оны 9-р сарын 1-ний №199-рт Баян-Өлгий аймгийн хэсэг иргэдийн нэргүй захидлыг нийтэлснийхээ төлөө шүүхийн өмнө буруутан болоод байна. Захидалд нэр дурдагдсан Баян-Өлгий аймгийн Засаг дарга С.Хавал болон нэр бүхий төрийн 6 албан тушаалтан Чингэлтэй дүүргийн шүүхэд нэр төр гутаасан иргэний хэргээр нэхэмжлэл гаргаснаас энэ явдал үүдэлтэй юм.

Монгол Улсын Үндсэн Хуулиар баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхэд нь зарим тохиолдолд иргэдэд хамгаалалт хэрэгтэй болдог. Аливаа буруу, далд, бугшмал, зохисгүй үйлдэл, үйл ажиллагааг илчлэхдээ учирч болзошгүй эрсдлээс өөрийгөө хамгаалан нэрээ нууцлах нь иргэний эрх юм. Ийм ч учраас улс орнуудад шүгэлдэгч буюу мэдээлэгч, мөн сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль тогтоомж үйлчилдэг. Манай улсад одоогоор ийм хамгаалалт байхгүй байгаа нь төрийн албан тушаалтнуудын өөрсдийн буруутай үйл ажиллагааг далдлах, зөвтгөх боломж олгож буй нь харамсалтай. Эрх мэдэлтнүүд нэр төр гутаахтай холбоотой Иргэний ба Эрүүгийн хуулийн зүйл заалтыг хэвлэл мэдээллийг айлгах, сүрдүүлэх, дарамтлах цензур болгон ашиглаж байгаа нь аливаа хэлбэрийн цензурыг хориглосон Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн заалтыг ноцтой зөрчиж байгаагийн илрэл юм. Нөгөөтэйгүүр, энэ нь үнэн бодит мэдээлэл олж авах олон нийтийн эрхийг ч бүдүүлгээр зөрчиж буй хэрэг. Шүүмжлэлт сэтгүүл зүй хөгжихийн хэрээр хэвлэл мэдээлэл нийгмийн хоточ нохой байж, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх жинхэнэ дөрөв дэх засаглал болж чадна. Гэтэл иргэдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгосон хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүрийг хэрэгт татаж, төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагааг шүүмжилснийг нь шүүх буруутай гэж үзээд байвал Монгол улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжих боломжгүй юм.

Иймд та бүхнийг гаргасан шийдвэрээ эргэн харж, “Нийгмийн толь” сонины толгой компьютерийг буцааж өгнө гэдэгт найдаж байна.

“Глоб Интернэшнл” нь 1999 онд байгуулагдсан, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмждэг Монголын төрийн бус байгууллага юм.

Хуулбарыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид.



Тэргүүн

Х.Наранжаргал